

Governance code of conduct of Unet Asset Management LLC

Overview

The “Governance code of conduct” of Unet Asset Management LLC is a comprehensive governance framework designed to promote responsible, transparent, and ethical management practices aligned with international standards. Its primary goal is to protect the rights and interests of investors and stakeholders while supporting long-term value creation and sustainable growth.

The Code establishes guiding principles that emphasize a strong and independent Board of Directors, effective risk and internal control systems, respect for stakeholder rights, and adherence to high standards of professionalism and ethics. A core theme of the code is the commitment to fair decision-making free from conflicts of interest and undue influence, especially from shareholders or political groups. The Board is tasked with ensuring transparent financial reporting, overseeing risk management, and maintaining an ethical corporate culture.

Additionally, the company commits to maintaining high standards of compliance, establishing clear internal and external reporting lines, and fostering a culture that discourages misconduct and encourages whistleblowing.

The Code also outlines specific mechanisms for internal control, risk management, compliance, and stakeholder engagement, ensuring that all employees—from executives to staff—follow the laws, regulations, and internal rules that govern the company and its managed funds. Ethical business conduct, anti-corruption policies, and confidential information protection are strictly enforced.

Ultimately, this Code serves as both a moral compass and a practical guide, reinforcing Unet Asset Management LLC’s commitment to good governance, responsible investment, and the trust of its investors and partners.

ҮНЭТ АССЕТ МЕНЕЖМЕНТ ХХК-ИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

“Үнэт Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн Засаглалын кодекс /цаашид “кодекс” гэх/-ийн зорилго нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн засаглалын зарчим, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд дэмжлэг үзүүлэх, компанийн сайн засаглалыг бий болгоход оршино.

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих гол субъект нь Төлөөлөн удирдах зөвлөл бөгөөд хувьцаа эзэмшигч нь Төлөөлөн удирдах зөвлөл болон хөндлөнгийн аудитаар дамжуулан компанид зохистой засаглалын бүтэц, зохион байгуулалт бүрэлдсэн эсэхэд хяналт тавина.

Энэхүү кодексийг компанийн бүх түвшний үйл ажиллагааны хүрээнд оролцогчид болох эрх бүхий албан тушаалтан, удирдлага, ажилтнууд дагаж мөрдөх бөгөөд кодекс заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.

I. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДСЭН ЗАРЧИМ

“Үнэт Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн засаглалын тогтолцоо нь дараах үндсэн зарчимд тулгуурлана. Үүнд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт:

- Олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэцтэй байна.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааны тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх хороодыг байгуулж болох бөгөөд эцсийн хариуцлагыг өөрөө хүлээнэ.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн зөв, бүрэн бүтэн, тэнцвэртэй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллана.

2. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын зохистой тогтолцоо:

- Олон улсын сайн туршлагад нийцсэн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлэх бөгөөд хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд тогтмол хяналт тавина.

3. Оролцогч талуудын эрх ашиг:

- Оролцогч талуудын хуулиар болон гэрээгээр тогтоосон эрх ашгийг хүндэтгэн шийдвэр гаргадаг тогтолцоо бүрдүүлсэн хөрөнгө оруулалтын мэргэжлийн байгууллага байх бөгөөд зохицуулагч байгууллагатай үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэнэ.
- Харилцагч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг ямагт тэргүүн ээлжинд тавих зарчмыг чанд мөрдөн ажиллах замаар хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн мэргэжлийн компани байна.
- Компани болон Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, холбогдох мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.

4. Мэргэжлийн өндөр ур чадвартай, ёс зүйтэй, шударга байх::

- Компанийн удирдлага, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэг, дадлага туршлага, хариуцлагатай ажиллах чадвар нь хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээх чухал хучин зүйл болохыг харгалзан эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудад тавих шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн тогтоож, сонгон шалгаруулалтыг ил тод зохион байгуулах, цалин урамшууллыг зохистой тогтоох, ажлын байрандаа мэдлэг, дадлага, ур чадвараа дээшлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Олон улсын сайн туршлагад нийцсэн Компанийн соёл, Ёс зүйн дүрмийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал болон ажилтнууд бүгд чанд баримтлан ажиллах, хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох, урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- Компанийн эрх бүхий албан тушаалтан, бүх түвшний удирдлага, ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагаандаа ёс зүйтэй, шударга байх зарчмыг баримталж, шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс ангид байхад онцгой анхаарч, Ёс зүйн дүрмийн чанд мөрдөнө.

5. Хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд баримтлан ажиллах:

- Компанийн болон удирдаж буй сангийн үйл ажиллагаанд мөрдөх хууль тогтоомж, дүрэм журмын болон хөрөнгө оруулалтын зах зээлд нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, зөвлөмжийн мэдээллийн сан бүрдүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, бүх шатны ажилтан санд чөлөөтэй нэвтрэн мэдээлэл авдаг байх, хууль дүрэм журам, стандартыг чанд мөрдөх, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо бүрдүүлэн ажиллана.

6. Бие даасан, хараат бус байх:

- Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн шийдвэр гаргахдаа тухайн төсөл нь улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд оруулах хувь нэмэр, нийгэм эдийн засгийн болон байгаль орчинд үзүүлэх нөлөө, үр өгөөжтэй байдлыг харгалзан үзэж, улс төрийн нам, санхүү, эдийн засгийн аливаа бүлэглэл, мөн түүнчлэн хувьцаа эзэмшигчийн нөлөөнөөс хараат бусаар мэргэжлийн шийдвэр гаргах зарчмыг чанд баримтална.

7. Компанийн соёл:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанидаа бизнесийн ёс зүй, хариуцлагын өндөр хэм хэмжээг тогтоож, Гүйцэтгэх захирал болон ажилтнууд мөрдлөг болгож хэвшүүлэхэд манлайлна.

“Үнэт Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн үйл ажиллагаанд баримталж буй алсын хараа, эрхэм зорилго, уриа үг болон үнэт зүйлсийг кодекс багтаан, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулна.

1. Алсын хараа: “Үнэ цэн хуваалцан хамтын хүчээр салбартаа тэргүүлэх компани болно.”

2. Эрхэм зорилго: “Өрсөлдөж биш хамтарч, өмчилж биш хуваалцдаг үнэт бизнес”

3. Уриа үг: “Хамтын үнэ цэн”

4. Үнэт зүйлс:

1. Ёс зүйтэй, мэргэжлийн ур чадвар:

Өндөр ёс зүйтэй байж хувийн ашиг сонирхолыг хөрөнгө оруулагч, харилцагчийн болон компанийн эрх ашгаас ангид байлгаж мэргэжлийн ур чадвараар өндөр бүтээмжтэй ажиллаж өөрийгөө болон бусдыг хөгжүүлэгч байх;

2. Өндөр хариуцлага:

Бусдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн ухамсарлаж, үндсэн зорилгодоо хүрэхийн тулд үүрэг

даалгавраа чанартайгаар биелүүлж, багийн гүйцэтгэлийг өндөр байлгах;

3. Шударга, зарчимч байдал:

Өөрөө өөртөө шударгаар хандаж хувь хүний болон байгууллагын үнэт зүйлст итгэл дүүрэн байж түүндээ үнэнч зарчимтай хоёргүй сэтгэлээ зориулах;

4. Оролцогч талуудын эрх ашгийг эрхэмлэгч:

Зах зээлийн зохицуулагч байгууллага, оролцогч талуудын хууль болон гэрээгээр тогтоосон эрхийг эрхэмлэн үзэж компанийн ажилтнууд, харилцагч, хөрөнгө оруулагч нарын ашиг сонирхлыг үргэлж анхаарлын төвд байлгаж мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;

5. Хамтын үнэ цэн бүтээгч:

Олон нийт, бизнес эрхлэгч нартай хамтран бизнесийн олон шинэ нэгдлүүдийг бий болгох замаар эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн хөгжилд өндөр хувь нэмэр оруулах;

6. Тогтвортой хөгжлийн бодлогыг манлайлагч:

Нийгэм болон байгаль орчинд ээлтэйгээр үйл ажиллагаа явуулахад бусдыг үлгэрлэн манлайлж, илүү санал санаачлагатай байж, тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх;

7. Бүтээлч шийдэл гаргагч:

Аливаад бүтээлчээр хандаж хөрөнгө оруулагч, харилцагч байгууллага, ажилтнуудад тулгамдаж буй бэрхшээлийг цаг алдалгүй, хамгийн зөв шийдлийг санал болгож, байнгийн тасралтгүй хөгжиж байх;

II. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Олон улсын сайн туршлагад нийцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалтыг бий болгох бөгөөд гишүүдийн гуравны нэгээс багагүй хувь нь хараат бус гишүүн байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирлын цалин урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд тодорхой чиг үүрэг бүхий хариуцсан байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журамтай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд хороо байгуулаагүй байх үед чиг үүргийг Төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд байгуулж болох аудитын хороо нь хорооны үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд байгуулж болох нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь нэр дэвшүүлэх, цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлого болон залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.

Компанийн болон удирдаж буй сангийн үйл ажиллагааны талаар зөвшөөрөгдсөн мэдээллийг эрх бүхий этгээдэд цаг тухай бүр тогтоосон хэлбэрээр хүргэдэг байх, эдгээр мэдээлэл нь бодитой, үнэн зөв, баталгаажсан байх нь хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээх үндсэн нөхцөлийн нэг мөн. Үүний хүрээнд:

- Гүйцэтгэх захирал нь компанийн зорилго, хувьцаа эзэмшигч болон засаглалын бүтэц, зорилго, зорилт, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, тэдгээрт нөлөөлж болох гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөлөл зэрэг дүрэм журмаар тогтоосон мэдээллийг хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч болон зохицуулах байгууллагад хүргэх, ил тод болгох үүрэгтэй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлөөс

баталсан компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг дагаж мөрдөнө;

- Удирдаж буй сангийн хөрөнгө оруулагчдад хүргэх, бусад оролцогч талуудад хүргэх зэргээр мэдээллийг ангилах бөгөөд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль тогтоомж, хөрөнгө оруулагчидтай байгуулсан гэрээ, Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд, зохицуулах байгууллагад, хөрөнгө оруулагчдад хүргэхээр тогтоосон мэдээллийг цаг тухайд нь хүргэх тогтолцоо бүрдүүлсэн байх бөгөөд уг мэдээлэл бүрэн, үнэн зөв, цаг хугацаандаа байх асуудлыг хариуцах ажилтныг томилсон байна;
- Мэдээллийг харилцагч, хөрөнгө оруулагчдад хүргэх харилцааг өөрийн цахим хуудсаар дамжуулан хэрэгжүүлнэ;
- Компани дотоод мэдээлэл эсхүл нууцын зэрэглэлтэй мэдээллийн талаарх хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавина;

III. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Компанийн үйл ажиллагаанд болон удирдаж буй сангийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоо бүрдүүлэх нь компанийн засаглалын болон хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмыг хэрэгжүүлэх үндэс юм. Компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорино.

Компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх, өөрөөр хэлбэл ажилтан болон удирдаж буй сан тус бүрийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, ажилтанд үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтийг хянах "эрсдэлээс хамгаалах хамгаалалтын тэргүүн шугам"-ыг бий болгоно.

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг болох эрсдэлийн удирдлагын бие даасан нэгж нь "эрсдэлээс хамгаалах хоёрдох шугам" байх бөгөөд тухайн нэгжийн эрх үүрэг, шийдвэр гаргах хүрээ, хариуцлага болон тайлагнах зарчмыг оновчтой тогтоох нь гүйцэтгэх удирдлагын үүрэг байна.

Эрсдэлийн удирдлагын нэгжийг байгуулахдаа дараах асуудалд анхаарал хандуулна. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагын нэгжийн ажилтан нь компанийн болон удирдаж буй сангийн дотоод мэдээллийн системд нэвтрэх эрхтэй байх бөгөөд хариуцаж буй сангийн талаар бүхий л мэдээллийг тухай бүр хүлээн авах эрхээр хангагдсан байна.
- Эрсдэлийг судлах, дүгнэх, бууруулах талаар үндсэн үйл ажиллагааны нэгжүүдээс хийж гүйцэтгэсэн ажлыг нэгтгэн дүгнэж, эцсийн үнэлгээ хийх, зөвлөмж өгөх үүрэг хүлээх, энэ үүргийг хэрэгжүүлэх чадавхтай байх;
- Компанийн эрсдэл даах сонирхол, эрсдэлийн хязгаарын талаар санал боловсруулж, Гүйцэтгэх захиралд танилцуулан, ТУЗ-өөр батлуулах;
- Удирдаж буй сангийн хөрөнгө оруулах төслийн эрсдэлийн талаар үндсэн үйл ажиллагааны нэгжээс хийж гүйцэтгэсэн судалгааны тайланд дүгнэлт гаргах, санал боловсруулах.

IV. ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Компани нь олон улсын сайн туршлагад нийцсэн засаглал, дотоод хяналтын тогтолцоог бий болгох зорилгын хүрээнд бие даасан дотоод хяналтын нэгж эсхүл ажилтантай байна. Дотоод хяналтын нэгж нь компанийн хяналтын болон эрсдэлийн удирдлага, засаглалын тогтолцооны талаар хараат бус дүгнэлт гаргаж, сайжруулах асуудлаар зөвлөмж боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, холбогдох арга хэмжээг зохион байгуулахад нь гүйцэтгэх удирдлагад зөвлөх үүрэгтэй байх бөгөөд компанийн "эрсдэлээс хамгаалах хамгаалалтын гурав дахь шугам"-ын үүрэг гүйцэтгэнэ.

- Дотоод хяналтын нэгж нь компанийн мэдээллийн системд нэвтрэх эрхтэй байх бөгөөд удирдлага болон ажилтнууд дотоод хяналтын нэгжээс шаардсан бүхий л мэдээ, мэдээлэл тайланг гаргаж өгөх үүрэг хүлээнэ;
- Дотоод хяналтын нэгж нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт болон зөвлөмжүүд тухайлбал, COSO-гийн зарчим болон Дотоод аудитын олон улсын институтийн стандартыг мөрдөнө;
- Дотоод хяналтын албаны ажилтнууд нь компанийн үндсэн үйл ажиллагааны дүрэм журам, зөвлөмж, стандарт зэргийг мэддэг, энэ чиглэлээр суралцах, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх боломжоор хангагдсан байна;
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дотоод хяналтын нэгжийн ажилтнуудыг томилох, цалин хөлсийг тогтоох, бусад шаардлагатай дэмжлэг үзүүлэх замаар гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Аудитын хороо байгуулж болох бөгөөд хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.

V. КОМПЛАЕНС

Компани нь бие даасан комплаенсын хяналтын бүтэцтэй байх ба комплаенсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд Төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина. Комплаенсын үйл ажиллагааны удирдлага, хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлсэн байх нь компанийн соёлын чухал асуудал бөгөөд компанийн үнэ цэнийг өсгөх үндсэн хүчин зүйлийн нэг байна. Комплаенсын нэгж нь комплаенсын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, байнгын хяналт тавих, тайлагнах болон комплаенсын үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүний хүрээнд:

- Компанийн дотоод үйл ажиллагааны нэгж болон удирдаж буй сан тус бүрээр комплаенсын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, хянах асуудлыг хамарсан хяналтын тогтолцоо бүрдүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах нь Гүйцэтгэх захирлын үүрэг байна.
- Компани, удирдаж буй сангийн үйл ажиллагаанд болон ажлын байр, ажилбар бүрийн хувьд дагаж мөрдөх хууль, дүрэм журам, стандартын жагсаалт гаргах, хэрэгжүүлэх талаар ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах, удирдамж, зөвлөмж боловсруулах, комплаенсын үйл ажиллагаатай холбоотой

тулгамдсан асуудлаар зөвлөгөө өгөх зэрэг нь комплаенсын нэгжийн чиг үүрэг байна.

VI. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

Компанийн зүгээс оролцогч талуудын хууль болон гэрээгээр тогтоосон эрхийг хүндэтгэн үзэх, компанийн ажилтнууд, хөрөнгө оруулагчид, хамтран ажиллагч байгууллагуудын ашиг сонирхол болон байгаль орчин, нийгмийн хариуцлагын асуудлыг байнга анхаарлын төвд байлгах, гаргаж буй шийдвэр нь оролцогч талууд болон тэдэнтэй хамтрах ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг харгалзан үздэг байна. Компанийн үйл ажиллагаанд оролцогч талууд гэдэгт хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын баг, ажилтан, зохицуулагч байгууллага, хамтран ажиллаж буй компани зэрэг компанийн үйл ажиллагаанд оролцож буй холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг ойлгоно. Оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэх үйл ажиллагааны хүрээнд:

- Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна.
- Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирал нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.
- Компани нь хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.
- Компани нь оролцогч талуудтай хамтран ажиллахдаа холбогдох хууль, дүрэм, гэрээ хэлцлийг мөрдөж ажиллах ба оролцогч талуудын хууль, журамд заасан эрх ашгийг зөрчсөн үйл ажиллагаа явуулахгүй. Түүнчлэн оролцогч талуудыг компанитай холбоотой бөгөөд зөвшөөрөгдсөн асуудлаар мэдээлэл авах боломжоор хангаж, үнэн зөв мэдээлэл өгнө.
- Компани нь ажилтантай байгуулах Хөдөлмөрийн болон Хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журамд компанийн болон ажилтны хүлээх үүрэг хариуцлагыг тусгаж, хэрэгжилтийг хянах тогтолцоо бүрдүүлэн ажиллах ба компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа хууль бус, ёс зүйгүй үйлдлийн талаар ажилтнууд Төлөөлөн удирдах зөвлөлд чөлөөтэй мэдээлж шийдвэрлүүлэх эрхтэй байх бөгөөд компанийн Гүйцэтгэх захирал тэдний эрхийг аливаа дүрэм журмаар хязгаарлахгүй.
- Компанийн нийгмийн хариуцлага, хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмыг холбогдох дүрэм журамд тусгахдаа хариуцлагатай хөрөнгө оруулалтын болон компанийн нийгмийн хариуцлагын тухай олон улсын стандартад нийцүүлсэн байна.
- Компани нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, хөрөнгө оруулалтын менежерүүдтэй хамтын ажиллагааг эрчимжүүлэх бодлого баримтална.
- Бусад сангуудтай зөвшилцөн санхүүжигч компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нэгдмэл байр суурьтай оролцох замаар тэдгээрийн засаглал, удирдлага болон бусад шийдвэрт зохистой нөлөө үзүүлэхийг эрмэлзэнэ.
- Бусад хөрөнгө оруулагчидтай зөвшилцөх, хамтран ажиллахдаа зах зээлийг урвуулан ашиглах, үгсэн хуйвалдахыг хориглосон хуулийн зохицуулалтыг зөрчихөөс сэргийлнэ;

- Компани нь хөрөнгийн зах зээлийг хянах зохицуулагч байгууллагатай хариуцлагатай хөрөнгө оруулалт болон компанийн засаглалын зарчмыг хэвшүүлэх асуудлаар хамтран ажиллах, санал солилцохыг эрхэмлэнэ.
- Зохицуулагч байгууллага болон гишүүнчлэлтэй байгууллагаас санаачилсан хэлэлцүүлэг, семинар зэрэг арга хэмжээнд идэвхтэй оролцох, туршлага мэдээлэл солилцох;
- Хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд нөлөөлнө гэж үзвэл шинээр боловсруулж байгаа болон нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хууль, дүрэм, журмын төслийг судлан саналаа тусгуулах, уг асуудлыг бусад хөрөнгө оруулагчидтай хамтран хэлэлцэх санаачилага гаргана.
- Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.
- Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.
- Харилцагч, хөрөнгө оруулагч болон ажилтнуудын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлнэ.

VII. КОМПАНИЙН СОЁЛ, ЁС ЗҮЙ

Компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлөөс ёс зүйн дүрмийг батлан, хэрэгжилтэд хяналт тавина. Энэхүү ёс зүйн дүрэм нь компанийн стратеги, эрсдэлийн удирдлагын болон цалин урамшууллын тогтолцоотой нягт уялдсан байх бөгөөд дараах асуудлыг хамарсан байна. Үүнд:

- **Хууль сахиж, бодлого, журмыг дагаж мөрдөх:** Компанийн болон удирдаж буй сангийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг чанд мөрдөж хэвших нь эрх бүхий албан тушаалтан болон бүх ажилтны заавал мөрдөх үүрэг бөгөөд хөдөлмөрийн дотоод журамд заасан дотоод дэг журмыг нягт баримталж хэвшүүлэх, зөрчсөн тохиолдолд заавал хариуцлага хүлээдэг байх;
- **Сонирхлын зөрчлөөс зайлсхийх:** Компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтан бүр өдөр тутмын үйл ажиллагаа, шийдвэр гаргалтандаа үүсч болзошгүй сонирхлын зөрчлөөс ангид байх;
- **Авлигын эсрэг бодлого:** Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан авлигад өртөхөөс сэргийлэх дүрэм журам тогтоон мөрдүүлэх;
- **Дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйлдэл:** Удирдаж буй сангаас хөрөнгө оруулсан компанийн үнэт цаасны арилжаанд дотоод мэдээлэл ашиглан оролцохыг хориглох, ийм арилжаа хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих;
- **Мэдээллийн нууцыг хадгалах:** Компанийн ажилтан, албан тушаалтнууд нь ажил үүргийн хүрээнд олж авсан мэдээллийн нууцыг цаг үргэлжид чандлан хадгалж, гуравдагч этгээдэд задруулахгүй байх зохицуулалтыг бүрдүүлэх;
- **Эрсдэлийг бууруулах:** Эрх бүхий албан тушаалтан болон ажилтан үйлдэл бүрээ нягт хянаж, аливаа эрсдэлд хүргэх үйлдэл, эс үйлдэл хийхээс зайлсхийх үүрэгтэй гэдгийг сайтар ухамсарласан байх;
- **Хууль бус, ёс бус үйлдлийг таслан зогсоох тогтолцоо:** Залилан, худал мэдээлэл гаргах, бусдын нэр хүндэд хохирол учруулах, мөнгө угаахын эсрэг болон шударга өрсөлдөөний зарчмыг зөрчих, дотоод мэдээлэл ашиглан

арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглах, танил тал харах, харилцагч хөрөнгө оруулагчидтай болон бусад ажилтнуудтай ёс бус харилцах, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, маргаан дэгдээх зэрэг компанийн нэр хүндэд хохирол учруулах зан авир гаргах зэргээр хууль бус, ёс бус үйлдэл гаргахгүй байх, гаргасан тохиолдолд хариуцлага тооцдог тогтолцоо бүрдүүлэх, урьдчилан сэргийлдэг, нөхөрсөг бүтээлч уур амьсгал бүрдүүлэх;

- **Шүгэл үлээх буюу зөрчлийг мэдээлэх тогтолцоо:** Компанийн ажилтнууд, сангийн хөрөнгө оруулагчид болон бусад үйлчилгээ үзүүлэгч компаниудын зүгээс компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь компанийн соёл, ёс зүйн дүрэм болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн болон зөрчихөд хүргэхүйц үйлдэл, зан авир гаргаж байгаа талаар Гүйцэтгэх захиралд болон ТУЗ-д мэдээлэх зохистой механизм бүрдүүлэх;

VIII. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах явцад сонирхлын зөрчил үүсэх бөгөөд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, тэдний итгэлийг хүлээхийн тулд энэхүү зөрчлийг зохицуулах журам нь ойлгомжтой, тодорхой байна. Сонирхлын зөрчил үүссэн үед эрх бүхий албан тушаалтан энэ тухайгаа мэдэгдэх, тухайн асуудлыг шийдвэрлэхэд оролцохгүй байх, мэдэгдэхгүй сонирхлын зөрчил бүхий шийдвэр гаргаснаас бусдад хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох дүрэм журамд тусгасан байна.

“ҮНЭТ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК